ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд заасан Ерөнхий сайдыг огцруулах журмыг бүхэлд нь өөрчлөн найруулж 4 хэсэгтэй байсныг 2 хэсэгтэй болгон өөрчилсөн.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэсэг;

1992 оны Үндсэн хуулийн анхны эх	2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт
Дөчин гуравдугаар зүйл 1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. 2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. 3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ. 4. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьбал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.	Дөчин гуравдугаар зүйл 1.Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно. 2.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д "*Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагыг энэ хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад шалтгаанаар хангаагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т заасны дагуу Засгийн газрыг огцруулах тухай санал гаргах үндэслэл болно.*" гэж заасан. Тус заалтын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т гэсэн хэсэг 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хасагдсан бөгөөд тус заалтыг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын

зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, ...холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж заасан. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах хэсэгт "Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагыг энэ хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад шалтгаанаар хангаагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т заасны дагуу Засгийн газрыг огцруулах тухай санал гаргах үндэслэл болно." гэж Засгийн газарт хариуцлага хүлээлгэх үндэслэл, эрх зүйн суурийг бүрдүүлсэн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өнгөрсөн хугацаанд 22 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байх ба 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 18 дугаар зүйлийн 18.3 дах хэсгийн "8.1-д зааснаас" гэснийг "8 дугаар зүйлд зааснаас" гэж өөрчлөн найруулж нэг удаа өөрчлөлт оруулсан байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбогдуулан Засгийн газрыг огцруулах санал гаргах хуулийн үзэл баримтлал, тухайн зүйлийн зорилго, агуулга өөрчлөгдөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1-д "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах хэсгийг Үндсэн хуульд нийцүүлэх зорилгоор тус зүйлийн Үндсэн хуулийн "Дөчин гуравдугаар зүйлийн 4-т" гэснийг "Дөчин гуравдугаар зүйлийн 1-д" гэж өөрчлөн найруулах шаардлагатай байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуульд бусад хууль нийцсэн байх Үндсэн хуулийн зарчим хангагдахаас гадна өөрчлөлт оруулж буй заалтын практикт хэрэгжих боломж бүрдсэнээр, Засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

-----o0o-----